

*Б.Анхбаяр-ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 8062-р дамжааны суралцагч.
дэд хурандаа
Ц.Бямбаагчаа -ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага,
стратегийн профессорын багийн профессор.
доктор (PhD), хурандаа*

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА, АЛБАДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Хураангуй: Гамшиг осол тохиолдсон үед гамшигаас хамгаалах албадын гүйцэтгэх үүрэг, хамтын ажиллагаа маш чухал юм. Гамшигийн үед гамшигаас хамгаалах албадын шуурхай байдлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг боловсронгуй болгох талаар энэхүү сэдвийг судлан таниулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Гамшигаас хамгаалах удирдлага, гамшигийн тухай ойлголт, албадын хамтын ажиллагаа

Оршил: Аливаа улс орны хөгжлийн үйл явцын үед тулгардаг хүндрэл бэрхшээлийн нэг бол болзошгүй гамшиг түүнээс учрах аюул юм.

Дэлхийн дулаарал цаг агаарын өөрчлөлтөөс шалтгаалж байгалын гамшиг, техникийн холбогдолтой осол хүний санаатай болон санамсар болгоомжгүй байдлаас болж үүссэн гамшиг ослын тоо, төрөл өсөн нэмэгдсээр байна.

Манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, объектын болон ой хээрийн түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэл зэрэг байгалийн гамшигаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавьжны тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгслийн осол, цацраг идэвхит хордолт, химийн хорт бодисын алдагдалт зэргээс хүний амь нас эрсдэх, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчинд ихээхэн хохирол учирсаар байна.

Байгалийн гамшигт, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол нь улс орны олон зуун жилийн хичээнгүй хөдөлмөр, оролдлого, хичээл зүтгэлийг ганцхан хормын дотор сүйрүүлж, олон хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг устгаж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хэдэн арван жилээр хойшлуулсан түүхийн олон жишээ баримтууд байдаг.

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 4300 гаруй гамшиг, техникийн холбогдолтой осол тохиолдож, 200 гаруй хүн хүн амь насаа алдаж байна. Болзошгүй гамшигийн аюулын тоо давтамж өсөх чиг хандлага нэмэгдэж байгаатай холбогдуулан гамшигаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн

чадавхийг сайжруулах, хоорондын уялдаа холбоо. хамтын ажиллагааг сайжруулах бодит шаардлага бий болж байна.

Иймд өнөөдрийн энэ түвшинд хүрсэн хөгжил. дэвшлийг хэрхэн тогтвортой байлгах, цаашид яаж хөгжүүлэх, хөгжил цэцэглэлтэд ямар хүчин зүйл саад болж. сүйрүүлж буй байдал тэдгээрийг хэрхэн багасгах, арилгах. эрсдэлийг бууруулахад зөв зүйтэй удирдлага, арга хэмжээг оновчтой зөв авч хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал асуудал болоод байна.

Гамшгийн хамгаалах удирдлага.

УдирОлага бол байгууллагын зорилтуудыг томъёолж түүнд хүрэхийн тулд зайлшгүй төлөвлөх. зохион байгуулах, идэвхижүүлэх. хянах үйл ажиллагаа юм.

Удирдлагын салбарын тэргүүний онолч Питер Ф.Друкер удирдлагыг тодорхойлохдоо *"Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй, бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм"* гэж,

Удирдахуй гэдэг нь байгууллага түүний гишүүдийн өмнөх зорилтыг биелүүлэхийн тулд хүмүүстэй ажиллаж, хүмүүсийн тусламжтайгаар ажил явуулахыг хэлнэ хэмээн тодорхойлсон байна.

Шуурхай удирдлага гэж төв орон нутгийн онцгой байдлын анги, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирүүлсэн гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээ мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ, үнэлгээ хийж шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах үйл ажиллагаа юм.

Гамшгаас хамгаалах удирдлага гэдэг нь нэн тэргүүнд эрсдэл ихтэй хүн амын эмзэг байдлыг бууруулах болои гамшиг тохиолдсон үед аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг авч явуулах. хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг аль болох үр дүнтэй болоход чиглэгдсэн өргөн хүрээтэй, хөгжлийн чиг хандлагатай уялдсан цогц үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл. гамшгийн янз бүрийн үе шатанд бүх түвшинд авч хэрэгжүүлэх үндсэн бодлого, засаг захиргааны шийдвэр. шуурхай үйл ажиллагаа гэж үзэж болно¹.

Гамшгаас хамгаалах удирдлагын мөн чанар нь Онцгой байдлын албыг удирдах (газар, хэлтэс, алба, нэгж, анги. салбар) байгууллага, албан тушаалтнуудын хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх. бэлтгэл бэлэн байдлыг хангах, тавигдсан үүргийг биелүүлэхэд чиглэсэн зорилготой үйл ажиллагаанд оршино.

Гамшгаас хамгаалах удирдлагын зорилго нь тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд удирдах болон удирдагдах байгууллагын тайван болон

¹ О.Уржин, П.Цэвэл нарын "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" УБ.. 2017, 26 тал

аврах үйл ажиллагааны цагийн боломжийг зүй зохистой дээд зэргийн үр дүнтэй ашиглахад оршино.

Гамшгаас хамгаалах удирдлагын зорилго нь¹:

1. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирч болох гамшгийн болзошгүй хохиролыг бууруулах, хэрэв боломжтой бол бүр мөсөн арилгах,
2. Гамшгийн аюулд нэрвэгдэгсдийг аврах. яаралтай бөгөөд нэн хэрэгцээтэй тусламж үзүүлэх,
3. Урьд өмнө байсан эрсдэлээс бага эрсдэлтэй болгохын тулд үр дүнтэй, урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг авахад оршино.

Олон улсад гамшгаас хамгаалах удирдлага нь бэлэн байдлыг хангах, аюулыг бууруулах, сэргээн босгох ба сэргээн засварлах, аврах хор уршгийг арилгах гэсэн 4 үе шаттай байдаг бөгөөд үүнийгээ гамшгийн мөчлөг гэж үздэг байна.

АНУ-ын гамшгийн нэрт судлаач Фредерик Кьюнигийн хэлснээр "Тамшгаас хамгаалах удирдлагын салбарт хамгийн их боломж, бололцоо олгодог үе нь бэлэн байдлыг хангах үе" гэжээ. Үнэхээр бэлэн байдлыг цаг тухайд нь хангах явдал маш их ач холбогдолтой байдаг юм.

Гамшгаас хамгаалах удирдлагын онол нь удирдлагын үндсэн катигори ойлголтууд, зүй тогтол, зарчмуудыг өөртөө багтааж, гамшгаас хамгаалах байгууллагын үйл ажиллагааны онол, практикийг нэгтгэн дүгнэсэн, гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоог бүрдүүлэн төгөлдөржүүлэх, удирдлагын үр ашигтай үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмжийг агуулсан шинжлэх ухааны үзэл баримтлал юм².

Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах ба хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг биелүүлэхэд гамшгаас хамгаалах байгууллага, албаны удирдлага, бүх түвшний штаб, аврах анги, салбар, мэргэжлийн ангиуд, орон нутгийн захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хооронд хэрэгжүүлэх арга хэмжээ ба эрх мэдлийн хувиарлалт хэрхэн хийгдсэнийг гамшгийн удирдлагын систем гэнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа:

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн үе шатаар тасралтгүй явагдах, нэгээс нөгөөд шийлжих багц үйл ажиллагаа бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатуудад тасралтгүй хэрэгжих арга хэмжээнүүдийн цогц юм.

¹ Мөн тэнд

■ О.Үржин, П.Цэвэл нарын "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" УБ.. 2017, 26 тал

Гамшгийн өмнөх түвшинд болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх үе шат хамаарна. Гамшгийн эрсдэлийг бууруулах замаар гамшгаас үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах. гамшгийн үед шуурхай ажиллах бэлэн байдлыг хангахад энэхүү үе шатын зорилго оршдог. Гамшгийн эрсдэлийг бууруулахын үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд аюулт үзэгдэл үүсэхээс сэргийлэх, эсвэл нийгмийн эмзэг байдлыг бууруулах замаар хохирлын хэмжээг багасгаж тогтвортой хөгжлийн нөхцлийг бүрдүүлэх юм. Энэ үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийх, нийгмийн эмзэг байдлыг бууруулах. болзошгүй аюулын сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ хамаардаг. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээ нь эрсдэлийн үнэлгээнд үндэслэгдэн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах, сургалт дадлага, сургууль хийх, хүч хэрэгслийн чадавхыг сайжруулах зэрэг асуудлуудаас бүрдэнэ.

Гамшгийн үед хөнөөлийн голомтод нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах, яаралтай тусламж үзүүлэх хийгээд хор уршгийг арилгах, хойшлуулшгүй бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эрэн хайх, аврах гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж хүргэх, гамшгийн голомтоос гаргах үйл ажиллагааг, харин хор уршгийг арилгах гэж хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах зэрэг гамшгийг хамгийн бага хохиролтойгоор гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг хэлнэ.

Гамшгийн дараа үүссэн нөхцөл байдлыг хэвийн болгоход чиглэсэн сэргээн босгох үйл ажиллагаа явагдана. Сэргээн босгох ажилд сэргээн засварлах, шинэчлэн байгуулах арга хэмжээнүүд багтах бөгөөд түүний үндсэн зорилго нь хүн амын гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах, ядуурлыг бууруулах, үйл ажиллагаа нь доголдсон, тасалдсан үйлдвэрлэлийн объект, байгууллагын үйл ажиллагааг хэвийн болгох, тогтвортой байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэж, улс орны хөгжил, үндэсний аюулгүй байдлыг¹ хангахад дэмжлэг үзүүлэхэд оршдог. Үүнээс гадна сэргээн босгох үйл ажиллагаа бол алдаагаа засах боломжийг олгодог.²

Гамшгаас хамгаалах чадавх нь улс орны гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, бэлэн байдал. эрсдэл эмзэг байдлын үнэлгээ, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг. боловсрол, мэргэшсэн

¹ Сэржмядаг Д/Тамшгаас хамгаалах менежентийн тогтолцоо: хөгжил, хандлага". УБ., 2013. 97-р тал.

² Сэржмядаг Д/Тамшгаас хамгаалах менежентийн тогтолцоо: хөгжил, хандлага". УБ.. 2013.100-р

тал.

албан хаагч, тэдгээрийн ур чадвар, дадал, аврах ажиллагааны багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох, гамшгийн нөөцийг бүрдүүлэх, байршуулахаас шууд хамааралтай байдаг.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ^{1 2 3}.

Улс орны гамшгаас хамгаалах асуудал нь тухайн улсын гамшгаас хамгаалах чадавхитай шууд холбоотой билээ. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл гэдэгт онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, техник хэрэгсэл, эрэлч иохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, түүний техник хэрэгсэл⁴ байхаар хамааруулж ойлгоно.

Мэргэжлийн ангийг Монгол Улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд цэргийн жинхэнэ алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуульд элсэхийн, емнох насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, өрх толгойлсон эх /эцэг/ хамаарахгүй.

Гамшгийн удирдлагын уламжлалт одоогийн системд төр төрийн бус байгууллага, салбаруудын хоорондын харилцан холбоо сул, үйл ажиллагааны давхцал ихтэйгээс үр дүн хангалтгүй байдаг.

ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА:

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулинд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын албыг Засгийн газар, аймаг, нийслэл, дүүрэгт орон нутгийн айбп тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна⁴. гэж хуульчилсан.

¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.1. УБ.. 2017

² Мөн хуулийн 23.1.

³ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24.1. УБ.. 2017

⁴ Мөн хуулийн 22.6.

Гамшгаас хамгаалах улсын алба нь гамшгаас хамгаалах үйл (урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, сэргээн босгох) ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны холбогдох байгууллагыг түшиглэсэн эрхэлсэн салбарынхаа хүрээнд гамшгаас хамгаалах үүрэг хүлээсэн орон тооны бус нэгжийг хэлнэ.

Гамшгаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн дагуу тодорхой үүрэг хүлээх улсын болон аймаг нийслэл, сум, дүүрэг баг хорооны орон тооны бус алба байгуулан ажиллуулдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 97 дугаар “Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай” тогтоол гарсан. Үүнд:

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

№	Улсын албаны нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага	Улсын албаны дарга
1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба	Байгаль орчин, аяаа жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Байгаль орчин. аялал жуулчлалын сайд
2	Барилга, хот байгуулахын алба	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Барилга, хот байгуулалтын сайд
3	Зам, тээврийн алба	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Зам, тээврийн хөгжлийн сайд
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн алба	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
5	Хүн а.м. нийгмийк хамгааллын алба	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
6	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
7	Түлш, эрчим хүчний алба	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Эрчим хүчний сайд
8	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тов байгууллага	Эрүүл мэндийн сайд
9	Мэд, ээлэл, харилцаа холбооны алба	Хариуцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Хариуцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга
10	Мэргэжлийн болон иаирагийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэргэжлийн хяналтын газрын дарга

11	Хэв журам сахиулах алба	Гэмт хэрэглэй тэмнэх, нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байллыг хангах үүрэг бүхий торийн захиргааны байгууллага	Цагдаагийн ерөнхий газрын дарга
12	Сурталчилгааны алба	-	Засгийн газрын Хэвлэл МЭДЭЭЛЭЛ, олон нийттэй харилцах хэлтсийн дарга

зэрэг албууд ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 52 дугаар тушаалаар “Тамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ыг баталсан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд гамшгаас хамгаалах улсын алба (цаашид Улсын алба гэх)-ны гүйцэтгэх нийтлэг чиг үүргийг тодорхойлох, түншлэл хамтын ажиллагаа, салбар хоорондын удирдлага, зохицуулалтыг уялдуулахад энэхүү журмын зорилго оршино. Улсын алба нь гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангана.

Улсын алба нь гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, сургалт, дадлага зохион байгуулах, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага бусад улсын албатай харилцан ажиллах, мэдээлэл солилцох зэрэг арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.

Улсын албаны дарга нь тухайн төрийн захиргааны төв байгууллагад сайд, төрийн захиргааны байгууллагад дарга нь байх бөгөөд улсын албаны удирдлага (цаашид "штаб" гэх)-ыг энэхүү журамд заасны дагуу томилоогжуулан удирдана.

Улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцан ажиллах орон тооны албан хаагчтай байна. Улсын алба нь энэхүү нийтлэг журмын хүрээнд эрхэлсэн салбарын онцлогийг тусгасан журам боловсруулан мөрдөж болно.

Гамшгаас хамгаалах улсын алба дараах чиг үүрэгтэй :

- Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;
- хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33.1. УБ., 2017

- салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох. мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт. бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

- гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах;
- салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдаг хангах;

- гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх;

- орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

- гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;

- голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах;

- хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

- гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

- гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаархи мэдээ, тайлан гаргах.

Гамшгаас хамгаалах улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ороо тооны албан хаагчтай байна.

Засаг дарга нь нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох. орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх эрхтэй.

ХАМТЫН АЖИЛЛАГАА.

Хамтын ажиллагааны зохион байгуулалтын зорилго нь:

- гамшгаас урьдчилан сэргийлэх. гамшгийг даван туулах, гамшгаас хамгаалах арилгах талаар хамтарсан арга хэмжээг төлөвлөх. зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоо;

- гамшгийг арилгах үүргийг шийдвэрлэхэд оролцож буй хүн хүч, техник хэрэгсэл, эд хөрөнгийг оновчтой ашиглах явдлыг хангах.

Хамтын ажиллагааны зохион байгуулалтын арга:

- төрийн болон захиргааны бусад холбогдох байгууллагын менежерүүд, албан тушаалтнуудын хамтарсан шийдвэрийг боловсруулах;

- хамтарсан төв болон бусад түр удирдлагын байгууллагуудыг байгуулж, төрийн бусад байгууллагын төлөөлөгчдийг хамруулах.

Хамтын ажиллагааны зохион байгуулалтын дараалал:

- харилцан мэдээллийг солилцох;
- үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтын ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах. түүнчлэн уйл ажиллагааны бусад баримт бичгүүдийг ч хамтран боловсруулах;
- хамтарсан үйл ажиллагааны дарааллыг уялдуулах;
- хөгжил. үйлдвэрлэл. шинэ тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд оролцох;
- норматив хууль тогтоомжийг хамтран бэлтгэх;
- хамтарсан дадлага сургуулилт хийх, сургалт явуулах;
- бага хурал, семинар явуулах. туршлага солилцох.

САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ.

Одоогоор манай улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засгийн газар, гамшгаас хамгаалах албад (холбогдох салбарын яамд болон гамшгаас хамгаалах байгууллага), төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод, сайн дурын байгууллага, хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн байгууллагууд ямар нэг хэмжээгээр оролцож, хамтран ажиллаж байгаа хэдий ч зонхилох тохиолдолд онцгой байдлын байгууллагууд, улс, аймаг, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах албад. мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний үндсэн дээр хоёр талын хамтын ажиллагаа явуулж байгаа билээ.

Харин улс, орон нутгийн хэтийн хөгжил, ирээдүйд чиглэсэн алсын хараатай бодлогын чанартай асуудлаар хамтран ажиллах явдал дутагдалтай. олон талын оролцоо хангалтгүй байна.

Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд тохиолдсон уруйн үерийн нөхцөл байдлаас харахад гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын гамшгийн үеийн шуурхай удирдлага. зохицуулалт, аврах хор уршгийг арилгах ажиллагаа харьцангуй сайжирсан байдалтай, харин хот байгуулалт, төлөвлөлт, газар зохион байгуулалт, инженерийн байгууламжийг бүхэлд нь хамарсан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж. хотын хөгжлийн бодлого төлөвлөлтөнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх ажил ихээхэн дутагдалтай байгаа нь ажиглагддаг,

Аливаа эрсдэлийг гамшгийн хэмжээнд хүргэхгүй байх үүднээс урьдчилан үнэлж. түүнийг бууруулах эсвэл болзошгүй хохирлын хэмжээг хязгаарлах арга хэмжээг шат дараатай. системтэйгээр хөгжлийн бодлого төлөвлөлтөнд тусгаж хэрэгжүүлэх. хөрөнгө нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах асуудлыг бүх түвшинд яам. агентлаг. байгууллагуудын оролцоотойгоор төрийн зохицуулалттайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулинд гамшгаас хамгаалах албадын хамтын ажиллагааны талаар тодорхой тусгаж оруулаагүй ч тухайн хуулийн 34 дүгээр зүйлд хуулийн этгээд, иргэний эрх, үүрэгт ерөнхийлөн тусгасан байдаг. Тодруулбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.1.гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, 34.2.3.үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, 34.2.5.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах, 34.2.6.гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах зэргээр тусгасан байдаг.

Дүгнэлт

Гамшгийн үеийн шуурхай удирдагчийн гол үүрэг бол ажлыг амжилттай иж бүрэн гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж өгөх явдал юм.

Удирдагчийн мэдлэг, туршлага нэр хүнд, хувийн болон мэргэжлийн чанар нь аврах ажилд бэлтгэх, гүйцэтгэх дуусгах бүх явцад эн тэргүүний нөлөө үзүүлнэ. Удирдагч их хэмжээний бүрэн эрх эдлэх бөгөөд ажлын амжилт, бие бүрэлдэхүүний эрүүл мэнд аюулгүй байдлын төлөө хариуцлага хүлээх ёстой.

Монгол Улсын төр, засаг Гамшгаас хамгаалах тухай хуулийг 2003 онд батлан хэрэгжүүлж эхэлснээс хойших харьцангуй богино хугацаанд авсан арга хэмжээнүүдийн үр дүнд бодлогын болон үйл ажиллагааны хүрээнд шинэчлэлт тасралтгүй өрнөж, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо төлөвшиж, олон ажлыг хийж хэрэгжүүлж байгаа ч гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хуулинд заасан шаардлагаар жигд зохион байгуулж, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, хандлагыг сайжруулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд нилээдгүй зүйлийг хийх шаардлага тулгарч байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд олон нийтийн ойлголт, мэдлэг, оролцоо, гамшгаас хамгаалах албадын чадамж, төрийн бодлого болон эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдааг хангах, гамшгийн эрт зарлан мэдээлэх тогтолцоо, бэлэн байдал, хор уршгийг арилгах үр дүнтэй цогц менежментийг бий болгох шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдагч зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн

болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлдэг.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын албыг Засгийн газар, аймаг, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна гэж хуульчилсан.